ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 03 сарын 05 өдөр Дугаар 74 Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас
хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор батлсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Геологийн судалгааны төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон, нийт 30,010,465.8 (гучин сая арван мянга дөрвөн зуун жаран таван төгрөг наян мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2."Геологийн судалгааны төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Н.Ганболдод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах, сэлбэг, материал болгон ашиглах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА А.АРИУНБОЛД

0000145

D:\Huraldaanii material\2019 on\2019.03.05 №4\Togtool.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 03 сарын 05-ний өдрийн
447 дугаар тогтоолын хавсралт

"ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Суудлын автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэр-лэсэн/ ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Суудлын автомашин, УАЗ-31512, УББ 40-01, арлын дугаар 31510020130948	2002/2002	3,807,623.90	3,807,623.90	-
2	Суудлын автомашин, УАЗ-31512, УБЯ 04-18, арлын дугаар 0661252	1998/2004	13,366,000.00	13,366,000.00	-
3	Суудлын автомашин, УАЗ-2206, УБГ 19-03, арлын дугаар 50472378	2005/2006	12,836,841.90	12,836,841.90	-
	Нийт дүн		**30,010,465.80**	**30,010,465.80**	**-**
			(гучин сая наян арван мянга дөрвөн зуун жаран таван төгрөг наян мөнгө)	(гучин сая наян арван мянга дөрвөн зуун жаран таван төгрөг наян мөнгө)	